

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО 2020



Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж энэ ч утгаараа мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2020 оны тооллогыг нийслэлийн Засаг даргын А/1282 тоот захирамж, дүүргийн Засаг даргын А/633 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллогыг амжилттай зохион байгуулж явууллаа.


Баянгол дүүрэг нь мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс тул тус дүүрэгт малтай өрх байхгүй бөгөөд дүүргийн нутаг дэвсгэрт буй тэжээвэр амьтдын тооллого явуулсан болно.

### **НЭГ. ДҮҮРГИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО**


Хүснэгт 1

Он	Туулай	Шувуу	Нохой	Муур	Гахай
<b>2016</b>	<b>0</b>	<b>22</b>	<b>3220</b>	<b>99</b>	<b>36</b>
<b>2017</b>	<b>0</b>	<b>19</b>	<b>3024</b>	<b>102</b>	<b>19</b>
<b>2018</b>	<b>0</b>	<b>67</b>	<b>2931</b>	<b>92</b>	<b>4</b>
<b>2019</b>	<b>4</b>	<b>56</b>	<b>2784</b>	<b>124</b>	<b>0</b>
<b>2020</b>	<b>6</b>	<b>58</b>	<b>2511</b>	<b>138</b>	<b>0</b>


Зураг 1




Зураг 2



Зураг 3



Зураг 4



Баянгол дүүргийн мал тэжээвэр амьтдын тоог 2016 оныг 2020 онтой харьцуулахад туулай 6, шувуу 163.6%, муур 39.4% өсч , нохой 22.0% , гахай 0 болж буурсан байна.

## ХОЁР. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, ТӨРӨЛ ХОРООДООР

Манай дүүргийн хувьд 25 хороотой бөгөөд 2020 оны жилийн эцсийн тооллогоор 2713

гэрийн тэжээвэр амьтан тоологдсон .Үүнээс 2511 буюу 92.6% нь нохой, 138 буюу 5.1% нь

муур, 6 буюу 0.2% нь туулай , 58 буюу 2,1% нь шувуу байна.

Хүснэгт 2

### 2020 оны тэжээвэр амьтдын тоо хороо тус бүрээр

д/д	Хороо	Тэжээвэр амьтан							
		нохой		муур		туулай		шувуу	
		2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
1	1-р хороо	41	35	4	3				
2	2-р хороо	18	21	13	8				
3	3-р хороо	20	31	2	4				
4	4-р хороо	37	28	9	7				
5	5-р хороо	22	19	18	16				
6	6-р хороо	34	21	3	7				
7	7-р хороо	27	32	5	5				
8	8-р хороо	26	21	1	0				
9	9-р хороо	161	131	5	5				
10	10-р хороо	429	343	1	5				
11	11-р хороо	280	251	4	4				
12	12-р хороо	28	30	2	6				
13	13-р хороо	11	17	8	8				
14	14-р хороо	9	12	6	2				
15	15-р хороо	15	14	4	7				
16	16-р хороо	220	219	8	12				
17	17-р хороо	26	15	1	3				
18	18-р хороо	6	12	0	0				
19	19-р хороо	11	9	2	2				
20	20-р хороо	90	72	5	5				
21	21-р хороо	578	444	14	11	4	6	21	20
22	22-р хороо	437	455	7	9			23	18
23	23-р хороо	258	256	2	2			12	20
24	24-р хороо		14		0				
25	25-р хороо		9		7				
	<b>Дүн</b>	<b>2784</b>	<b>2511</b>	<b>124</b>	<b>138</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>56</b>	<b>58</b>
	<b>Өсөлт</b>		<b>-272</b>		<b>14</b>		<b>2</b>		<b>2</b>

